

2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр

**ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг”-ийн Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлэх зорилтын хүрээнд I үе шатанд эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, салбарын алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлсэн байхаар, “2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2.1.8-д “Боловсролын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн хяналт шинжилгээг олон улсын жишиг аргачлалаар хийдэг тогтолцоонд шилжиж төрөөс хараат бус бие даасан институцийг бэхжүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлаас Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг хөгжүүлэх, хууль зүйн боловсрол, хуульчийн шалгалт, хуульчийн зөвшөөрөл үргэлжилсэн сургалт, хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ зэрэг уялдаа холбоо бүхий нэгдсэн тогтолцоо болон хуульчдын мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах нэгдсэн стандарт, мэргэжлийн хариуцлагын шинэ зохицуулалтыг бий болгох зорилгоор¹ 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан.

Хууль батлагдсанаас хойш 18 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь бүгд батлагдан гарсан бусад хуулиуд болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоолын дагуу өөрчилсөн, нэмэлт оруулсан, зарим заалтыг хүчингүй болгосон байна. Ийнхүү бие даасан үзэл баримтлалтайгаар тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байсан тохиолдол байхгүй байна.

Гэвч тус хуулийн зарим зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байсаар байна. Тухайлбал, Монголын Хуульчдын холбооны “магадлан итгэмжлэх” чиг үүрэг бол хууль зүйн сургуулиудын хөтөлбөрийг оюутны хэрэгцээнд нийцүүлэх, хуульчид хэрэгтэй мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, дадал суулгах хичээлүүд заахыг хууль зүйн сургуулиудаас шаардах, хууль зүйн боловсролыг дэлхий нийтийн түвшинд ойртуулах үр нөлөөтэй механизм юм.

Манай улсад хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хуульч этгээдэд чиглэсэн сургалтын байгууллагууд хуулийн байгууллагуудын дэргэд ажиллаж тэдгээрийг давтан сургах, тасралтгүй сургалтыг зохион байгуулж мэргэшүүлж Монгол Улсын эрх зүйн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна.

Монгол Улсад хууль зүйн үйлчилгээний чанарыг сайжруулах, хуульч бэлтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох нь дээд боловсролын сургалтын байгууллагаас эхлэх тул хууль зүйн сургуулийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах шаардлага байгаа **нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврын тайлангаас тодорхой харагдаж байна.**

Түүнчлэн хуульд заасан “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа”-ны нэр томъёоны талаарх зохицуулалтыг практик шаардлагыг үндэслэн оновчтой хувилбараар, харьцангуй өргөн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн тусгах зүйтэй байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр² тус хуулийн холбогдох зохицуулалт нь зорилгодоо хүрээгүй болон зорилгодоо хүрэхийн тулд хуулийн зохицуулалтыг сайжруулах, боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна гэж дүгнэсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

¹ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал 2011 он / хуулийн хувийн хэргээс авсан/

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төсөл 2 зүйлтэй байх бөгөөд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, түүнд хамаарах ажил мэргэжлийн талаар нэмэлт оруулах, хуулийн 57, 58 дугаар зүйлийг өөрчлөн найруулж хуульч бэлтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрх зүйч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага болон сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхтэй холбоотой харилцааны талаар тусгайлан тусгана. Ингэхдээ эрх зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөрийн агуулгад хувийн эрх зүйн чиглэлийн хичээлийг эзлэх цагийн хэмжээг тусгайлан тусгаж, Дээд боловсролын тухай хуульд уялдуулан эрх зүйч бэлтгэхэд тавигдах зарим шаардлагыг тусган боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт хувийн эрх зүйн чиглэлийн хичээлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх замаар энэ чиглэлийн хүний нөөц бэлтгэх, мөн дээр дурдсан сургалтын байгууллагуудын сургалтын үйл ажиллагаадаар дамжин зэрэгцэн хөгжиж байж хувийн эрх зүйн салбарын шинэтгэлийн бодит үр дүн, улс орны эдийн засгийн хөгжилд үзүүлж буй нөлөөг шинжлэх ухааны үндэстэй тогтоох, хууль хоорондын уялдаа холбоо, системчлэл, хууль хэрэглээ, шүүхийн практикт дүн шинжилгээ хийх, хувийн эрх зүйн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг хууль эрх зүйн хувьд хэрэгжих боломжтой болгох, тэр дундаа хууль зүйн сургуулийн хөтөлбөрт хувийн эрх зүйн шинэчлэлийг агуулгыг тусгах, түүнийг хуулиар эрх олж авсан мэргэжлийн холбоо болох Хуульчдын холбоо хяналт хэрэгжүүлэх замаар хувийн эрх зүйн шинэтгэлийн талаарх төрийн бодлогыг дэмжих, энэ замаар иргэд аж ахуйн нэгж хоорондын эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, иргэд аж ахуйн нэгжид шинэ тутамд тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, шүүхийн ачааллыг бууруулах, цаашлаад улсын төсвийн ачааллыг бууруулах нөхцөл бүрдүүлэх боломжтой юм.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

